

ТАНИЛЦУУЛГА

ХЭНД:	САНГИЙН ДЭД САЙД Т.ОЧИРХҮҮ, ТНБД Д.БАТТӨР ТАНАА
ХЭНЭЭС:	ТӨСВИЙН БОДЛОГЫН ГАЗАР
УТГА:	1.5 САЯ ТӨГРӨГИЙН ХУВЬ, ХИШИГ ХҮРТЭЭХ ТУХАЙ
ОГНОО:	2010-1-25
ХУУДАСНЫ ТОО:	3 ХУУДАС

УИХ-ын 2008 оны сонгуулиар улс төрийн намуудын зүгээс иргэн бүрт 1.0 сая төгрөг, 1.5 сая төгрөгийн хувь, хишиг хүртээх амлалтыг өгсөн билээ. Энэ амлалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дараах танилцуулгыг бэлтгэв.

Хүний хөгжил сангийн тухай хууль: Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Ерөнхий сайд болох үед хэлсэн үгэндээ “Нөхөн сэргээгдэхгүй нөөц баялгийг хүний нөөц болгон хувиргах” тухай дурдсан билээ.

Уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлогын эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялгийг өгөөж, үр ашгийг нь байнга хүртэхүйц баялаг болгон хувиргаж, иргэддээ хүртээх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор УИХ-ын 2009 оны намрын чуулганаар Хүний хөгжил сангийн тухай хуулийг батлан гаргасан билээ.

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлд Хүний хөгжил сангийн эх үүсвэрийг (1) стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого; (2) ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг; (3) хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашиг; (4) стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээл зэрэг эх үүсвэрээс тус тус бүрдүүлэхээр тооцсон.

Хүний хөгжил сангийн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан сангийн 2010 оны орлогын нийт эх үүсвэрийг 346.6 тэрбум төгрөг байхаар батласан. (Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг 94.0 тэрбум төгрөг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг 39.9 тэрбум төгрөг, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээл 212.7 тэрбум төгрөг, нийт 346.6 тэрбум төгрөг)

Зөвхөн албан хэрэгцээнд

Хүний хөгжил сангийн орлогын цаашдын хандлага: Хүний хөгжил сангийн орлого цаашдын хандлага нь уул уурхай, ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ ханшийн хэлбэлзэл, үйлдвэрлэлийн хэмжээнээс шууд хамааралтай. Нөгөө талаас, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд шуурхай оруулах нь сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Гэвч манай улсын эдийн засгийн өсөлтийг түргэтгэх томоохон уул уурхайн төсөл хөтөлбөрүүдээс зөвхөн “Оюу Толгой” төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ зурагдаж, бүтээн байгуулалтын ажил эхлээд байгаа боловч стратегийн бусад орд газрууд болох “Таван толгой”-н нүүрсний орд, ураны болон бусад ашигт малтмалын ордуудыг хэрхэн, ямар хэлбэрээр ашиглах, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хэзээ эхлэх нь тодорхойгүй байна. Нөгөө талаас, стратегийн ач холбогдол бүхий орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг ажлыг эхлүүлэхэд доод тал нь 3-4 жилийн хугацаа шаардлагатай. Тухайлбал “Оюу Толгой” ордын үйлдвэрлэл 2013 оноос эхлэхээр байгаа юм.

Иймд 2010-2012 онуудад стратегийн ач холбогдол бүхий томоохон орд газарт үйлдвэрлэл эхэлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ногдол ашгийн төлбөрөөр Хүний хөгжил санд иргэдэд шаардлагатай хувь, хишгийг хүртээхэд шаардагдах дорвитой орлогын эх үүсвэрийг бий болгох боломж хомс байна.

Иргэдэд хувь хүртээхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох боломжийн тухай: Үндэсний статистикийн газраас авсан мэдээгээр манай улсын хүн амын тоо 2.7 сая байгаа бөгөөд иргэн бүрт 1.5 сая төгрөгийн хувь, хишгийг хүртээхэд 4.1 их наяд төгрөгийн эх үүсвэр шаардлагатай бөгөөд уг хөрөнгийн эх үүсвэрийг 2012 он гэхэд Хүний хөгжил сангийн хуульд заасны дагуу улсын төсөвт ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээлийн эх үүсвэрээс бий болгох боломжгүй байна.

Иймд богино хугацаанд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхийн тулд “Оюу Толгой”, “Таван Толгой” болон бусад стратегийн орд газруудын хувьцааг хөрөнгийн зах зээл дээр шууд болон шууд бус хэлбэрээр арилжаалах (дээрх ордын хувьцааны тодорхой хэсгийг шууд зарах, эсхүл төрийн өмчийн компани байгуулан эдгээр төрийн өмчит аж ахуйн нэгжээр дамжуулах зарах, эсхүл багцлан зарах гэх мэт) замаар богино хугацаанд шаардлагатай эх үүсвэрийг бий болгож болох талтай. (Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1 дэх хэсэгт энэ тухай заасан байна)

Гэхдээ стратегийн томоохон ордын хувьцааг гадаад, дотоодын зах зээл дээр арилжихад шаардлагатай бэлтгэл ажлыг хийх, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд нилээд хугацаа шаардлагатай юм. Түүнчлэн стратегийн ашигт малтмалын ордыг хувьцаа хэлбэрээр хөрөнгийн зах зээл дээр арилжих нь манай улсын эдийн засгийн бие даасан байдалд эрсдэл учруулж болохыг анхаарвал зохино. Манай Улстай ижил, зэсийн орлогоос төсөв, эдийн засаг нь шууд хамааралтай Чили Улсын хувьд харин эсрэгээрээ өөрийн орны томоохон зэсийн орд газруудыг гадаадын хөрөнгө оруулагчдаас төрийн мэдэлд авч, нийгэмчилж байсан түүхтэй. (Ерөнхийлөгч “Salvador Allende”-ын үед)

Иргэдэд хувь хүртээснээс үүсэх сөрөг үр дагавар: Ашигт малтмалын бүтээгдэхүүн болох нөхөн сэргээгдэхгүй баялгийг нөхөн сэргээгдэх, байнга, үеийн үед үр өгөөжөө өгдөг санхүүгийн баялаг болгон хувиргах нь бидний нэн чухал зорилт юм.

Гэвч улс төрийн намуудын дээрх амлалтыг хэрэгжүүлэн иргэн бүрт 1.5 сая төгрөгийн хувь, хишигийг Хүний хөгжил сангийн хуульд заасны дагуу хүртээх тохиолдолд олон сөрөг үр дагаварыг үүсгэнэ. Тухайлбал:

- Инфляцийн түвшин өсөх;
- Ирээдүй хойч үед өвлүүлэх баялагийн хэмжээ нөхөн сэргээгдэхгүй нөөцийн нэгэн адил дундарч багассаар тодорхой хугацааны дараа бүр мөсөн үгүй болох;
- Төсвийн дарамт ихсэх;
- Иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээг өөхшүүлэх;
- Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийхэд хүндрэл учрах.

Өнгөрсөн 2006-2008 онуудад дэлхийн зах зээл дээрх цэвэр зэсийн үнийн өсөлтөөс үүдэн бий болсон төсвийн зарлагын өсөлт нь манай улсын инфляцийн түвшинг 17.2-22.1 хувь хүрэхэд шууд нөлөөлсөн билээ.

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлд хишиг, хувь хүртэх хэлбэр, зарчмыг тусгасан бөгөөд (1) тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр, (2) орон сууц худалдаж авсны төлбөр, (3) бэлэн мөнгө, (4) эрүүл мэнд боловсролын үйлчилгээний төлбөр зэрэг хэлбэрүүд багтжээ.

Иргэдийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын төлбөр, орон сууцны төлбөр, эрүүл мэнд боловсролын үйлчилгээний төлбөрийг хийх хэлбэрээр хувь, хишиг хүртээх нь эцсийн үр дүнд бэлэн мөнгөөр хувь хишиг хүртээсэнтэй адил, инфляцийг огцом нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай. (Иргэдийн нийгмийн даатгалын төлбөр, орон сууцны төлбөр, эрүүл мэнд боловсролын үйлчилгээний төлбөрийг хүний хөгжил сангаас хийх нь иргэдэд их хэмжээний бэлэн мөнгөний эх үүсвэр, хуримтлалыг бий болгох нь тодорхой юм)